



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/10/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал.....	12
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмол сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.24 № 01/232
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сум нь тайлант онд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хоёрдогч түүхий эд ангилан авах цех, арьс шир боловсруулах цех, тахианы аж ахуй байгуулах, улсын хөрөнгө оруулалтаар Баянхангай сумаас сумын төв хүртэлх 45 км хатуу хучилттай замын ажил, 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн 38 зорилт 109 арга хэмжээний хэрэгжилтийг 96,1 хувиар дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийн дагуу гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын 5,064,602.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 192,207.1 мянган төгрөгийн бараа материал, 10,577.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 54,031.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлэн тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,043,573.60	935,528.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	518,691.30	648,351.80
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	266,024.20	195,239.70
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	258,858.10	91,936.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		6,019,510.80	1,130,991.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	6,019,510.80	1,130,991.10
39200	Биет хөрөнгө		5,889,715.90	1,116,547.40
39300	Биет бус хөрөнгө	13	129,794.90	14,443.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		7,063,084.50	2,066,519.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		20,903.90	9,646.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	20,903.90	9,646.80
41300	Өглөг	17а, 17б	20,903.90	9,646.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,042,180.50	2,056,872.60
51	Засгийн газрын хувь оролцоо		7,042,180.50	2,056,872.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,339,394.50	583,063.40
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		1,339,394.50	583,063.40
51200	Хуримтлагдсан үр дүн		2,930,575.60	1,268,331.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,772,210.40	205,478.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		7,063,084.50	2,066,519.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,238,485.90	1,600,574.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО		163,045.60	279,570.90
110	Орлогын албан татвар		64,258.90	191,999.40
1100	Хувь хүний орлогын албан татвар		64,258.90	199,754.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0	-7,754.60
113	Хөрөнгийн албан татвар		68,644.80	46,551.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж		30,141.90	41,020.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	573,146.30	384,819.30
120	Нийтлэг татварын бус орлого		573,146.30	384,819.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,502,293.90	936,184.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,878,078.50	1,126,135.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,876,078.50	975,928.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,862,948.50	946,125.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,524,700.40	289,152.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		198,990.40	39,799.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		342,603.60	328,871.00
2104	Хангамж, бараа материалын зардал		98,326.00	41,497.40
2105	Нормативт зардал		304,352.80	48,790.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		11,593.30	8,573.50
2107	Томилолт, зочны зардал		3,335.00	6,239.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		1,867.10	16,716.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		377,179.80	166,485.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,013,130.00	29,802.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,000.00	150,207.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		360,407.40	474,438.70
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		50,030.50	5,411,498.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		310,376.90	-4,937,060.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,761,725.70	1,318,618.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	163,045.60	279,570.90
110	Орлогын албан татвар	64,258.90	191,999.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	64,258.90	199,754.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-7,754.60
113	Хөрөнгийн албан татвар	68,644.80	46,551.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	30,141.90	41,020.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,141.20	6,550.10
1181	Газрын төлбөр	18,950.70	32,422.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,050.00	2,048.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,933.10	102,863.60
120	Нийтлэг татварын бус орлого	128,933.10	102,863.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,469,746.90	936,184.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,419,367.80	955,974.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,419,367.80	955,974.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,412,677.50	911,353.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,524,133.10	280,211.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,502.00	37,265.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	343,093.50	328,106.80
2104	Хангамж, бараа материалын зардал	50,147.90	24,945.90
2105	Нормативт зардал	168,008.60	52,241.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,762.20	8,533.70
2107	Томилолт, зочны зардал	4,891.40	5,819.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	3,026.60	30,829.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,112.10	143,398.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,006,690.30	44,621.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-	342,357.90	362,644.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	50,314.30	232,186.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50,314.30	232,186.70
2200	Дотоод эх үүсвэрээр	50,314.30	232,186.70
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-50,314.30	-232,186.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	-200	-797
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200	797
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	291,843.60	129,660.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,847.80	518,691.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	518,691.30	648,351.80

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,731,803.70	6,731,803.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	11,835.40	11,835.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,743,639.00	6,743,639.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-11,835.40	-11,835.40
9	Тайлант үеийн үр дүн	310,376.90	310,376.90
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,042,180.50	7,042,180.50
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,042,180.50	7,042,180.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-48,247.80	-48,247.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,993,932.70	6,993,932.70
19	Тайлант үеийн үр дүн	-4,937,060.10	-4,937,060.10
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,056,872.60	2,056,872.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,585,365,200.00	1,007,170,987.13	578,194,212.87
2	УРСГАЛ ЗАРДАЛ	936,420,700.00	774,187,326.13	162,233,373.87
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882,509,400.00	748,512,856.13	133,996,543.87
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,069,800.00	280,211,633.00	44,858,167.00
5	Үндсэн цалин	242,225,100.00	214,133,000.00	28,092,100.00
6	Нэмэгдэл	67,163,200.00	54,091,275.00	13,071,925.00
7	Урамшуулал	15,681,500.00	11,987,358.00	3,694,142.00
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,223,500.00	37,265,300.00	5,958,200.00
9	Тэтгэврийн даатгал	30,245,400.00	25,805,800.00	4,439,600.00
10	Тэтгэмжийн даатгал	3,244,500.00	2,769,800.00	474,700.00
11	ҮОМШӨ-ний даатгал	2,595,600.00	2,221,900.00	373,700.00
12	Ажилгүйдлийн даатгал	649,000.00	638,100.00	10,900.00
13	Эрүүл мэндийн даатгал	6,489,000.00	5,829,700.00	659,300.00
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	393,309,300.00	328,106,788.13	65,202,511.87
15	Гэрэл, цахилгаан	22,344,500.00	21,202,029.13	1,142,470.87
16	Түлш, халаалт	366,997,900.00	301,414,759.00	65,583,141.00
17	Цэвэр, бохир ус	3,966,900.00	5,490,000.00	-1,523,100.00
18	Хангамж, бараа материалын зардал	24,945,900.00	24,945,900.00	0.00
19	Бичиг хэрэг	1,523,900.00	1,523,900.00	0.00
20	Тээвэр, шатахуун	19,246,500.00	19,246,500.00	0.00
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,475,500.00	1,475,500.00	0.00
22	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000.00	2,700,000.00	0.00
23	Эд хогшил, урсгал засварын зардал	8,540,000.00	8,533,740.00	6,260.00
24	Урсгал засвар	8,540,000.00	8,533,740.00	6,260.00
25	Томилолт, зочны зардал	5,819,700.00	5,819,700.00	0.00
26	Дотоод албан томилолт	5,819,700.00	5,819,700.00	0.00
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,378,200.00	30,429,807.00	1,948,393.00
28	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	31,100,200.00	29,211,957.00	1,888,243.00
29	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	546,000.00	546,000.00	0.00
30	Даатгалын үйлчилгээ	300,000.00	283,850.00	16,150.00
31	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00	0.00
32	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	88,000.00	44,000.00
33	Бараа үйлчилгээний бусад зардал	49,223,000.00	33,199,988.00	16,023,012.00
34	Бараа үйлчилгээний бусад зардал	46,723,000.00	30,699,988.00	16,023,012.00
35	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00	0.00
36	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,911,300.00	25,674,470.00	28,236,830.00
37	Бусад урсгал шилжүүлэг	53,911,300.00	25,674,470.00	28,236,830.00
38	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,911,300.00	24,674,470.00	28,236,830.00
39	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00
40	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	498,944,500.00	232,186,661.00	266,757,839.00
41	Их засвар	258,690,500.00	171,391,844.00	87,298,656.00
42	Тоног төхөөрөмж	240,254,000.00	60,794,817.00	179,459,183.00
43	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000,000.00	797,000.00	149,203,000.00
44	Эргэж төлөгдөх зээл	150,000,000.00	797,000.00	149,203,000.00
45	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,585,365,200.00	1,162,737,544.13	422,627,655.87
46	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,944,500.00	173,944,500.00	0.00
47	Улсын төсвөөс санхүүжих			0.00
48	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	173,944,500.00	173,944,500.00	0.00
49	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	963,351,000.00	953,392,336.13	9,958,663.87
50	Орон нутгийн төсвөөс	963,351,000.00	953,392,336.13	9,958,663.87
51	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	448,069,700.00	35,400,708.00	412,668,992.00
52	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000,000.00	33,302,276.00	116,697,724.00
53	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,098,432.00	-2,098,432.00
54	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	298,069,700.00		298,069,700.00
55	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		202,917,178.00	
56	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		347,905,754.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,637.8	118,967.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,637.8	118,967.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,359.3	110,598.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,571.9	-
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	15,000.0	-
2104	Хангамж бараа материалын зардал	4,956.6	-
2105	Нарматив зардал	62,648.4	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	803.8	400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,378.6	110,198.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,278.5	8,368.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,632.8	8,368.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,645.7	-
11	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,637.8	118,967.6
12	Нэмэлт санхүүжилтийн орлого	262,637.8	118,967.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Угтаалцайдам сум нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй, эдийн засаг нийгмийн хүндрэлийг даван туулах, төр, нийгмийн салбарын үйлчилгээний цахим технологийн хүртээмжийг сайжруулан, эрүүл эрдэм мэдлэгтэй, хүнлэг ёс суртахуунтай иргэн, төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн авлигаас ангид цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжих эрхэм зорилготой.

Тайлант онд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хоёрдогч түүхий эд ангилан авах цех, арьс шир боловсруулах цех, тахианы аж ахуй байгуулах, улсын хөрөнгө оруулалтаар Баянхангай сумаас сумын төв хүртэлх 45 км зам хатуу хучилттай замын ажил, 150 ортой хүүхдийн цэцэрлэгийн шинэ барилгын ажлыг тус тус эхлүүлсэн байна.

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн 38 зорилт 109 арга хэмжээний хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар 96,1 хувиар дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 11 зорилт, 181 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 132 арга хэмжээ 100 хувь, 40 арга хэмжээ 70 хувь, 9 арга хэмжээг 30 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Угтаалцайдам сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2022 онд нийт 10 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан. Сумын Засаг даргын тамгын газрын даргаар томилогдсон ажлын хэсэг нь удирдамж батлуулан байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, анхан шатны баримтын хөтлөлт, бараа материалын зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэл, шилэн дансны хөтлөлт, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт

шинжилгээ хийж, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,996,565.1 мянган төгрөгөөр буюу 70,7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	518,691.3	648,351.7	129,660.4
Авлага	266,024.2	195,239.7	-70,784.5
Бараа материал	258,858.1	91,936.8	-166,921.3
Үндсэн хөрөнгө	6,019,510.8	1,130,991.1	-4,888,519.7
Нийт хөрөнгө	7,063,084.4	2,066,519.3	-4,996,565.1
Өр төлбөр	20,903.9	1,256.7	-19,647.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,042,180.5	2,065,262.6	-4,976,917.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,063,084.4	2,066,519.3	-4,996,565.1

Дээрх хүснэгтээс Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 648,351.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 129,660.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 230,046.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 123,061.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 195,239.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,784.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих Эрүүл мэндийн төвийн 54,031.0 мянган төгрөг, Соёлын төвийн 205.0 мянган төгрөгийн авлагыг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 91,936.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 166,921.3 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын 192,207.1 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,130,991.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,888,519.7 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын 5,064,602.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь оны эцэст 2,065,262.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,976,917.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн байгууллагуудын авлага, Засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 4,928,670.1 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 648,351.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 129,660.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	518,691.3	648,351.7	129,660.4
Төгрөг	518,691.3	648,351.7	129,660.4
Төрийн сангийн харилцах	514,714.1	648,284.0	133,569.9
Арилжааны банк дахь харилцах	3,977.2	67.7	-3,909.5
Дүн	518,691.3	648,351.7	129,660.4

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 648,284.0 мянган төгрөгийн үлдэгдлийн 42,3 хувь буюу 274,022.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 35,5 хувь буюу 230,046.6 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 18,2 хувь буюу 117,859.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 3,5 хувь буюу 22,590.0 мянган төгрөгийг Байгалийн нөхөн сэргээх барьцаа сангийн, 0,5 хувь буюу 3,765.8 мянган төгрөгийг Мал хамгаалах сангийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна.

Эмийн эргэлтийн сангийн үлэгдэл арилжааны банканд байршиж байгаа ба өмнөх оноос 3,909.5 мянган төгрөгөөр буурсан байна

Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 133,569.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 123,061.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Энэ нь тайлант хугацаанд хийгдэх хөрөнгө оруулалтын ажил бүрэн хийгдээгүйгээс шалтгаалжээ.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 195,239.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 70,784.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	392.1		-392.1
Байгууллагаас авах авлага	71,992.8	20,307.6	-51,685.2
Хувь хүмүүсээс авах авлага	193,638.3	174,932.1	-18,706.2
Дүн	266,024.2	195,239.7	-70,784.5

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 195,239.7 мянган төгрөгийн 89,6 хувийг хувь хүмүүсийн, 10,4 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 93,0 хувь буюу 162,703.1 мянган төгрөг нь хоршоо, хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах 20,307.6 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Авлагын үлдэгдэл оны эхнээс 70,784.5 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих сумын Эрүүл мэндийн төвийн 54,246.7 мянган төгрөгийн, соёлын төвийн 205.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг шилжүүлж, хувь хүмүүсээс авах хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн оны эхний үлдэгдлийг 26,019.0 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

- Тайлант оны цалингийн урьдчилгаа 1,400.0 мянган төгрөг, өмнөх оны цалингийн урьдчилгааны үлдэгдэл 900.0 мянган төгрөгийг суутган барагдуулаагүй ба өмнөх оны санхүүгийн аудитаар бичигдсэн төлбөрийн акт 1,970.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас төлж, авлагаар тайлагнаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Авлага дансны 2,891.5 мянган төгрөгийн эзэн тодорхойгүй үлдэгдлийг хариуцах эзэн холбогдогчийг тогтоож, авлагыг барагдуулах талаар албан шаардлага бичигдсэн.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 91,936.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 166,922.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	217,450.7	81,082.3	-136,368.3
Тусгай зориулалттай материал	151,443.7	44,506.9	-106,936.8
Эм боох материал	66,007.0	36,575.4	-29,431.5
Хангамжийн материал	41,407.4	5,854.5	-35,552.9
Бичиг хэргийн материал	3,526.2	1,251.3	-2,274.9
Аж ахуйн материал	5,505.6	4,018.0	-1,487.6
Сэлбэг хэрэгсэл	1,615.0	535.0	-1,080.0
Түлш, шатах тослох материал	32.3	50.2	17.9
Барилгын засварын материал	11,931.8		-11,931.8
Хүнсний материал	8,912.7		-8,912.6
Бусад хангамжийн материал	9,883.8		-9,883.8
Мал амьтад		5,000.0	5,000.0
Дүн	258,858.1	91,936.8	-166,922.1

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 91,936.8 мянган төгрөгийн 53,8 хувийг ЗДТГ, 43,6 хувийг эмийн эргэлтийн сан, 2,6 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 166,922.1 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС-ийн 67,762.5 мянган төгрөг, Цэцэрлэгийн 66,661.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 50,163.5 мянган төгрөг, Соёлын төвийн 7,619.5 мянган төгрөг, нийт 192,207.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

ЗДТГ-ын санхүүгийн тайланд бараа материалын тусгай зориулалтын материал дансанд 5,000.0 мянган төгрөгийн 20 толгой өсвөр хуц, 25,039.1 мянган төгрөгийн барилгын материалыг буруу ангилан бүртгэсэн алдааг аудитын явцад залруулсан.

Засаг даргын нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгө, бараа материалыг 3,680.832.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн алдааг залруулсан.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,482,510.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,396,662.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,747,411.6	2,467,887.4	-5,279,524.2
Барилга, байгууламж, орон сууц	5,503,643.0	698,941.3	-4,804,701.7
Авто-тээврийн хэрэгсэл	236,919.5	175,838.6	-61,080.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	575,402.1	396,294.7	-179,107.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	328,701.0	75,270.3	-253,430.7
Зам гүүрний байгууламж	842,801.1	768,255.1	-74,546.0
Түүх соёлын дурсгалт зүйл	10,000.0	10,000.0	0
Бусад үндсэн хөрөнгө	191,935.9	285,278.4	93,342.5
Дуусаагүй барилга, байгууламж	58,009.0	58,009.0	0
Биет бус хөрөнгө	131,761.0	14,623.0	-117,138.0
Программ хангамж	3,865.0	1,675.0	-2,190.0
Бусад биет бус хөрөнгө	127,896.0	12,948.0	-114,948.0
Дүн	7,879,172.6	2,482,510.4	-5,396,662.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдлийн 99,6 хувь буюу 2,472,347.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,14 хувь буюу 3,755.0 мянган төгрөгийг ИТХ, 0,26 хувь буюу 6,407.5 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 5,396,662.2 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагууд ЕБС-ийн 3,613,069.5 мянган төгрөг, Цэцэрлэгийн 356,802.6 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 427,269.2 мянган төгрөг, Соёлын төвийн 667,461.5 мянган төгрөг, нийт 5,064,602.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

ЗДТГ-ын санхүүгийн тайланд авто тээврийн хэрэгсэл дансанд 105,872.7 мянган төгрөгийн үнэ бүхий хадуур, үрлүүр, хаман боогчийг, тавилга эд хогшлын дансанд 14,960.0 мянган төгрөгийн хогийн савыг буруу ангилан бүртгэсэн алдааг аудитын явцад залруулсан.

Засаг даргын нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 4,500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,256.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 19,647.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өр	76.1	129.9	53.8
Байгууллагад төлөх өр	20,827.8	1,126.8	-19,701.0
Дүн	20,903.9	1,256.7	-19,647.2

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 1,256.7 мянган төгрөг болж, 19,701.0 мянган төгрөгөөр оны эхнээс буурсан нь Эрүүл мэндийн төвийн 16,981.8 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлж, эм эргэлтийн сангийн өглөг буурсантай холбоотой байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдэл 1,126.8 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 129.9 мянган төгрөг нь Засаг даргын тамгын газрын өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

Байгалийн нөхөн сэргээх барьцаа сангийн дансанд төвлөрсөн 8,390.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй алдааг аудитын явцад залруулсан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2065,3 сая төгрөг болж, өмнөх оноос 4,976.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,339,394.5	583,063.4	-756,331.1
Хуримтлагдсан үр дүн	2,930,575.6	1,276,721.2	-1,653,854.4
Өмнөх үеийн үр дүн	2,620,198.8	6,205,391.2	3,585,192.4
Тайлант үеийн үр дүн	310,376.8	-4,937,060.1	-4,626,683.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,772,210.4	205,478.1	-2566,732.3
Дүн	7,042,180.5	2,056,872.6	-4985,307.9

Эх сурвалж: Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,056,872.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,985,307.9 мянган төгрөгөөр буурсан.

Энэ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээр засгийн газрын сан 756,331.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээ 2,566,732.3 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүн 3,585,192.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн үр дүн 4,626,683.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Угтаалцайдам сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,244,200.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 310,300.0 мянган төгрөг, 2022 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 1,244,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 9,296.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 319,596.5 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны зардлыг 24,731.9 мянган төгрөгөөр бууруулан 1,219,468.1 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 150,000.0 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 333,944.5 мянган төгрөгөөр, нийт 1,703,412.6 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолоор баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулсан боловч жил бүр орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэмж баталж, төсвийн урсгал зардал ИТХ-ын Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг хассантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,163.1 мянган төгрөгөөр бууруулан 317,433.4 мянган төгрөгөөр, нийт урсгал үйл ажиллагааны зардлыг 118,047.4 мянган төгрөгөөр бууруулан 1,101,420.7 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн эх

үүсвэрийг 150,000.0 мянган төгрөгөөр, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 333,944.5 мянган төгрөгөөр, нийт 1,585,365.2 мянган төгрөгийг сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн “Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 05 дугаар тогтоолоор тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 317,433.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 645,917.6 мянган төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 173,944.5 мянган төгрөг, ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 80,000.0 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 218,069.7 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 150,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 975,658.6 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 645,917.6 мянган төгрөг, ОНХС-гийн шилжүүлгээр 173,944.5 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 92,372.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, Хоршоо хөгжүүлэх сан 45,088.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүйгээс дутуу олгож, 22,266.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,007,170.9 мянган төгрөг буюу 63,5 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 44,858.2 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 65,202.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 12,961.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,948.4 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 28,236.8 мянган төгрөг, хөрөнгийн зардал 266,757.8 мянган төгрөгөөр зардлууд хэмнэснээс шалтгаалсан байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, тогтмол зардал хэрэглээнээс, хөрөнгийн зардал тендер шалгаруулалт явагдаагүйгээс болон тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж олгогдоогүй зэрэгтэй холбоотойгоор зардал хэмнэгдсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 317,433.4 мянган төгрөг, гүйцэтгэлээр 290,061.7 мянган төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 91,4 хувиар биелүүлж, 8 нэр төрлийн орлого 6,3-47,9 хувиар тасарсан байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үйл ажиллагаа	59,313.8	48,699.8	10,614.0	82.1%
2	ЗДТГ-ын үйл ажиллагаа	405,616.9	347,199.7	58,417.2	85.6%
3	ЕБС-үйлчилгээ	234,081.0	229,081.0	5,000.0	97.9%
4	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	55,668.3	52,899.7	2,768.6	95%
5	Соёл урлагийн үйлчилгээ	129,872.9	77,661.7	52,211.2	59.8%
6	ЭМТ-ийн үйлчилгээ	20,867.8	18,645.3	2,222.5	89.4%
7	Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээ	529,944.5	232,186.7	297,757.8	43.8%
8	Хоршоо хөгжүүлэх сан	150,000.0	797.0	149,203.0	0.5%
		1,585,365.2	1,007,170.9	578,194.3	63.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 118,567.5 мянган төгрөг, ИТХ 400.0 мянган төгрөг, нийт 118,967.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	100%	59313,8	48699,8
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022 он	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	100%	405616,9	347199,7
3	Соёл урлагийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	59,8 %	129872,9	77661,7
4	Ерөнхий боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	59,8%	234081,0	229081,0
5	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	95%	55668,3	52899,7
6	ЭМТ-ийн үйлчилгээ	2022 он	Дулаан, цахилгаанаар бүрэн хангах	89,3%	20867,8	18645,3
7	Хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөр арга хэмжээ	2022 он	хөрөнгийн чанар байдал сайжирна	80%	196000,0	80000,0
8	Хоршоо хөгжүүлэх Хоёрдогч түүхийн эд авах, арьс шир боловсруулах цех байгуулах, тахианы аж ахуй байгуулах	2022 он	Жижиг дунд үйлдвэрлэлийг 3-аар нэмэгдүүлэх	100%	150000,0	1,0

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд Орон нутгаас хийгдэх хөрөнгийн зардлын 85,000.0 мянган төгрөгийн тендер зарлагдаагүй учраас хэрэгжилт 48 хувьтай байна. Сумын наадмын талбайн засвар хэрэгжээгүй нь ковид-19 цар тахлын улмаас бараа бүтээгдэхүүний үнэ ханш огцом өссөнөөс болж төсөвт өртөг хүрэлцэхгүй болсон. Мөн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтад нээлттэй тендер 3 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй зэргээс шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 23 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 1,585,365.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,780.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,835.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд тогтмол зардлаас нийт 65,202.6 мянган төгрөг, үүнээс цахилгааны зардлаас 1,142.5 мянган төгрөг буюу 5 хувь, түлш халаалтын зардлаас 65,583.2 мянган төгрөг буюу 18 хувь, бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 1,948.4 мянган төгрөг буюу 6,3 хувь, бараа үйлчилгээний бусад зардлаас 16,023.1 мянган төгрөг буюу 34,2 хувь тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих мэдээллээс 51 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 6,600.0 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 5,500.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, хоршоо хөгжүүлэх сангийн 11,387.5 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг болон ОНХС-ийн тендер шалгаруулалттай холбоотой 6 ажил мэдээлэхээс 140,057.0 мянган төгрөгийн 6 ажил мэдээлээгүй, мөн 6 ажилтай холбоотой шийдвэр, гэрээ мэдээлэхээс 132,901.0 мянган төгрөгийн 6 ажлын шийдвэр, гэрээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар гурван зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 156 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	3	17,047.4	3	17,047.4	100
Нийт дүн	3	17,047.4	3	17,047.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 3,693,722.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 3,693,722.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан үндсэн хөрөнгө, бараа материалыг 3,680.832.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Нэгтгэсэн санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 4,500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

3. Байгалийн нөхөн сэргээх барьцаа сангийн харилцах дансанд төвлөрсөн барьцааны 8,390.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 318,820.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 318,820.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 317,433.4 мянган төгрөг, гүйцэтгэлээр 290,061.7 мянган төгрөг төвлөрч, 8 нэр төрлийн орлого 6,3-47,9 хувиар буюу 22,375.2 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх, татварын байцаагчийг тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллуулах талаар аймгийн Татварын хэлтэст мэдэгдэх

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулбал зохих мэдээллээс 51 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Эмийн эргэлтийн сангийн 6,600.0 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээ, 5,500.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, Хоршоо хөгжүүлэх сангийн 11,387.5 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээг болон ОНХС-ийн тендер шалгаруулалттай холбоотой 140,057.0 мянган төгрөгийн 6 ажил мэдээлээгүй, 132,901.0 мянган төгрөгийн 6 ажлын шийдвэр, гэрээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДарга	2	3,685,332.0			2	3,685,332.0	2	3,685,332.0				
ЗДТГ	2	237,303.6			2	237,303.6	2	237,303.6				
БНСБС	1	8,390.0			1	8,390.0	1	8,390.0				
Дүн	4	3,696,025.1			3	3,693,722.0	3	3,693,722.0				

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Засаг дарга	1	22,375.2					1	22,375.2			
ЗДТГ	4	7,161.5	1	4,270.0	1	2,891.5	1	0				
Дүн	5	29,536.7	2	4,870.0	1	2,891.5	2	22,375.2				

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг дутуу байршуулсан	1	0					1	0
ОНХС-ийн дутуу мэдээлсэн	1	272,958.0					1	272,958.0
ХХС-ийн дутуу мэдээлсэн	1	11,387.5					1	11,387.5
ЭЭС-ийн дутуу мэдээлсэн	1	12,100.0					1	12,100.0
ЗДТГ	1	141,843.3					1	141,843.3
Дүн	5	438,288.8					5	438,288.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	5	438,288.8					5	438,288.8